

“МИАТ” БОЛОН “CATHAY PACIFIC” КОМПАНИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖИЖ МОНГОЛЧУУД АВСТРАЛИ РУУ ШИНЭ ГАРЦТАЙ БОЛЛОО

Австрали улс руу Монголчууд сурах гэж, мөн ажиллаж амьдрахаар зорьдог болсон. Өөрөөр хэлбэл Монголчуудын байнга зорчдог шахуу чиглэл юм. Энэ ч утгаараа Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК нислэгийн сүлжээгээ өргөжүүлэхээр Хонгконгийн /Cathay Pacific/ компанитай аяллын дугаар хамтран эзэмшиж нислэг үйлдэхээр хамтын ажиллагааны гэрээ үзэглээд байна. Хамтран ажиллах гэрээний дагуу 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдрөөс борлуулалтаа эхэлж хамтарсан нислэг үйлдэж эхлэх гэж байна. Өөрөөр хэлбэл өөрийн нислэг үйлдэж буй цэгээс цааших цэгүүд рүү аль нэг агаарын тээврийн компанийг түшиглэн тэдний сүлжээг ашиглан зорчигчдыг эцсийн цэгт нь хүргэх зорилгоор код хуваах гэрээ байгуулан зах зээлээ тэлэх гэж байгаа бөгөөд Австралийн Перт, Брисбен, Сидней, Мельбурн, Энэтхэгийн Шинэ Дели болон Сингапур руу хамтарсан нислэг

үйлдэж эдгээр хотуудаас Монгол руу зорчих зорчигч урсгалыг Хонгконгоор дамжуулан тээвэрлэх боломж нээгдэж байна.

Сүүлийн жилүүдэд агаарын тээврийн компаниуд аяллын дугаар хамтран эзэмших буюу код хуваах хэлбэрээр хамтран ажиллах нь ихсэж байгаа бөгөөд энэ нь хоёр болон түүнээс дээш агаарын тээврийн компаниуд харилцан тохиролцсон нислэгийн чиглэлд агаарын тээврийн компани тус бүр өөрийн үнээр, ижил аяллын дугаараар борлуулалт хийх хамтын ажиллагааны хэлбэрийг хэлдэг байна. Аяллын дугаарыг зарлахдаа гэрээний дагуу “МИАТ” компанийн OM аялалын дугаарыг гаргах бөгөөд зорчигчид Улаанбаатараас “МИАТ” –ын нислэгээр Хонгконгт хүрч цааш уг аяллын дугаараараа Хонгконгийн /Cathay Pacific/ компаниар дамжуулан дээр дурьдсан 3 улсын 6 хот руу хүрэх боломж бүрдэж байна.

Уг хамтын ажиллагаа МИАТ компанид Зүүн Өмнөд Ази руу чиглэсэн нислэгийн сүлжээг өргөжүүлж, давтамжаа нэмэгдүүлэх, нислэгийн зардлыг бууруулах, суудал ашиглалтыг нэмэгдүүлэх, агаарын хөлгийн ашиглалт сайжрах, шинэ зах зээлд нэвтрэх, эдийн засгийн хувьд зардал буурч ашиг орлого нэмэгдэх, боломжийг олгож байгаа бол үйлчлүүлэгчдэд нислэгийн сонголт нэмэгдэж, санхүүгийн хувьд бага зардлаар, олон сонголттой тарифаар үйлчлүүлэх боломж, тав тухтай байдлыг бий болгох юм. Мөн хамтран ажиллаж байгаа агаарын тээвэрлэгч 2 компанийн хооронд зорчигч болон тээш дамжуулах үйл явц хялбар болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Cathay Pacific компани нь дэлхийн 200 гаруй чиглэлд зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг Хонгконгийн агаарын тээврийн компани юм.

